



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/170

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай Г



Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 8,1 дүгээр зүйлийн 12.13, 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйл, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, 7.10, 7.11 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2024 оны А/87, А/219 дүгээр захирамжуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Менежер (Д.Баярсайхан)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2025 оны А/126 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАСАГ ДАРГА

9023100756  
9091364 & C6T23271

Ц.БАТТӨР

କାର୍ଯ୍ୟାଳୟ



ସା...ଶିଳ୍ପାଳୟ

କାର୍ଯ୍ୟାଳୟର ବିଭାଗୀୟ କର୍ମଚାରୀଙ୍କୁ ନିମ୍ନଲିଖିତ ଭାବରେ ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

୧. ନିମ୍ନଲିଖିତ କାର୍ଯ୍ୟାଳୟର ନିମ୍ନଲିଖିତ କର୍ମଚାରୀଙ୍କୁ ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ୧୦୧୯ ଟଙ୍କା ୦ ୩/୨୯୭ ଟଙ୍କା

ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି (ନି...ଶିଳ୍ପାଳୟ) - ଏହି ନିଯୁକ୍ତିପତ୍ର ।

୧. କାର୍ଯ୍ୟାଳୟର କାର୍ଯ୍ୟାଳୟର କର୍ମଚାରୀଙ୍କୁ ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

କାର୍ଯ୍ୟାଳୟର ନିମ୍ନଲିଖିତ କର୍ମଚାରୀଙ୍କୁ ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।


ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

୧୦୧୯ ୦୫ ୩୨

୧୦୧୯ ୦୫ ୩୨

ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।



ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି । ନିଯୁକ୍ତ କରାଯାଇଛି ।

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 02 дугаар сарын 18 ны өдрийн  
А/110 дугаар захирамжийн 1 дүгээр хэвсрэлт

ЭНГИЙН БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ДУГНӨЛТ  
ГАРГАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Дүүргийн менежер

Гишүүд:

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хотын стандарт тохижилт, нийтийн аж ахуйн  
хэлтсийн дарга

Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
Хяналтын хэлтсийн улсын Ахлах байцаагч  
(Зөвшилцсөнөөр)

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
хяналтын хэлтсийн улсын Ахлах байцаагч  
(Зөвшилцсөнөөр)

Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн  
газрын дарга

Сонгинохайрхан дүүргийн Татварын  
хэлтсийн дарга

Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн  
хэлтсийн дарга

Нарийн бичиг:

Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн  
Худалдаа үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн  
Хоол үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын  
2026 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн  
А/140 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**ЭНГИЙН БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, СЭРГЭЭХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ  
УДИРДАМЖ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл (цаашид тусгай зөвшөөрөл гэх), тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл энгийн зөвшөөрөл шинээр олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээн олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид Ажлын хэсэг гэх)-ээс Зөвшөөрлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтална.

**Хоёр.Ажлын хэсгийн ажиллах зарчим**

2.1.Ажлын хэсэг дараах асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана.

2.1.1.Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг шинээр олгох:

2.1.2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийн хугацааг сунгах

2.1.3.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

2.1.4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийг хүчингүй болгох

2.1.5.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, аж ахуйн нэгжийн нэр, захирлын нэр өөрчлөх

2.1.6.Ажлын хэсэг баримт бичгийн бүрдлийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйл заасны дагуу магадлан шалгаж, шийдвэрлэнэ.

2.1.7.Ажлын хэсэг магадлан шалгах хугацааг дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хуралдах бөгөөд хурлыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана.

2.1.8.Ажлын хэсгийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно. Хуралд Ажлын хэсгийн нарийн бичиг саналын эрхгүй оролцох бөгөөд ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

2.1.9 Ажлын хэсгийн хурлыг Дүүргийн менежер удирдах бөгөөд түүний эзгүйд асуудал хариуцсан нэгжийн дарга удирдаж болно.

**Гурав.Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах, магадлан шалгах, зохион байгуулах**

3.1.1.Төрийн үйлчилгээний <https://e-business.mn> цахим системд ирүүлсэн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүсэлт, нийслэлийн <https://ulaanbaatar.mn> цахим хуудасны "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ээр ирүүлсэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнүүд хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг магадлан шалгасны дараа жагсаалтыг гарган, танилцуулгыг бэлтгэнэ.

3.1.2. Ажлын хэсгийн нарийн бичиг магадлан шалгасан иргэн, хуулийн этгээдийн нэрсийн жагсалтыг гишүүдэд хурал болохоос ажлын 3 өдрийн өмнө хүргүүлнэ.

3.1.3. Ажлын хэсгийн гишүүд мэдээлэлтэй танилцан санал өгнө.

3.1.4. Ажлын хэсгийн нарийн бичиг хурлаар гишүүдийн саналыг авч тэмдэглэл хөтөлнө.

3.1.5. Хуралд оролцох боломжгүй гишүүн саналаа бичгээр гарган, гарын үсэг зурж баталгаажуулан, ажлын хэсгийн нарийн бичигт хурал болохоос 1 өдрийн өмнө ирүүлнэ.

Шаардлагатай тохиолдолд даргын зөвшөөрлөөр орлох албан тушаалтныг хуралд оролцуулна.

#### **Дөрөв. Шийдвэр гаргах**

4.1. Хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж, баталгаажуулах бөгөөд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар дэмжсэн эсхүл татгалзсан тухай дүгнэлт гаргана.

4.2. Ажлын хэсгийн нарийн бичиг хурлын тэмдэглэл, захирамжийн төслийг дүүргийн Засаг даргад хүргүүлж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэр гаргуулна.